



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/107

Жаргалант

「Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2025 оны А/264 дугаар тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 29 ний А/483 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээний хонин сүргийг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 29 хоногт багтаан шуурхай зохион байгуулсугай.

2.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд технологит хугацаанд нь гүйцэтгэх, уг ажлын чанар, явц гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (О.Банхар), урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын мэдээ тайлан, заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Э.Батдаваа) нарт үүрэг болгосугай.

3.Графикт хугацаанд малыг бүрэн дархлаажуулахыг Эм тун ХХК-ний захирал, малын их эмч (Э.Батцэцэг), Тахир нуур ХХК-ний малын эмч (С.Сугаррагчаа), Бодь тара ХХК- ний малын эмч (Г.Гомбосүрэн) нарт үүрэг болгосугай.

4.Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлдүүлэх, урьдчилан сэргийлэх тарилгад ажиллах хүн хүч, машин техникийн бэлэн байдлыг хангахыг, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн Хяналтын улсын байцаагч (О.Банхар)-т үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтийг хэрэгжүүлж үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501261



Сумын Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/107 Дугаар захирамжийн хавсралт

МАЛАМЬТАНЫ ГОЦ ХАЛДВАРТ ХОНИНЫ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	МЭҮН нэр	Дархлаажуулах малын тоо			Шаардлагатай вакцин, шингэлэгч						Санхүүжилт (төг)	
			Хонь	Хурга	Нийт	Вакцин /мян.тун/	Шингэлэг ч /литр/	Хайрцаг /ширхэг/	Задгай 250 мл /ширхэг/	Задгай 200 мл /ширхэг/	Нийт үйлчилгээ ний хөлс	Урьдчилг аа 50 хувь	
1	Норовлин	Эм Тун	44535	21965	66500	66.5	66.5	8	26		23275000	11637500	
		Бодь-Тара	22600	8900	31500	31.5	31.5	4	6		11025000	5512500	
		Тахир нуур	38000	16500	54500	54.5	54.5	7	8		19075000	9537500	
	Нийт		105135	47365	152500	152.5	152.5	19	40		53375000	26687500	